




Дан итгэлээр аврагдсан гэж үү? (Иаков ба Паулын маргаан)

“Захариа... Елизабет...
хоёул, Эзэний бүх
тушаал зааврыг өөгүй
дагаж, Бурханы өмнө
зөвт байлаа.” (Лук 1:6)
Гэсэн хэдий ч: “Зөвт хүн
алга. Ганц ч алга.” (Ром
3:10)



Та бид хоёрт хамаатай
энэ хоёр ишлэлтэй бид
өмнөх нийтлэлд нүүр туллаа. Дэндүү олон итгэгч Их
Эзэний Үгийг нэгтгэн ойлгохыг чухалд тооцдоггүй учраас
өрөөсгөл талыг бариад нөгөө талыг тоохгүй өнгөрөөх бүү
хэл үгүйсгэхэд хүрдэг. Гэтэл аль аль нь Ертөнцийн
Эзэний үнэн үг. Бүтээгч Эзэний “өмнө” зөвт байдаг хүний
тухай ишлэл, хүний өнцгөөс харсан харьцангуй үнэн.
Хүмүүс хоорондоо ялгаатай, зарим нь сайн үйлс хийдэг
шударга хүн, зарим нь муу үйлстэй муу хүн. Гэтэл
харанхуйг гийгүүлэгч дэнлүүний дөл нарны гэрэлд
харагдахгүйн адил хамгийн сайн хүний зөвт байдал
хэзээ ч Ертөнцийн төгс Эзэний зөвтийн хэмжүүрт
хүрэхгүй. Иймд “зөвт хүн алга” гэсэн нь Түүний өнцгөөс
харагддаг туйлын үнэн юм. Дээрх хоёр ишлэлийн оюун
бодолд гаргасан зөрчилдөөн энэ ойлголтоор арилахад
бид аль алинд нь итгэж чадахад хүрнэ.

Улмаар, энэ хоёр түвшний хараа нь хоёр сайн мэдээний
ялгааг бий болгоход хувь ихтэй. Хоёр сайн мэдээ байдаг
тухай та Галат 2:7-оос уншаарай. Зөвт үйлс үйлдэхийг
чухалчилдаг “хозлуулагсдын төлөөх сайн мэдээ” нь
харьцангуй үнэний хүрээнд өгөгдсөн. Харин Паулд



Дан итгэлээр аврагдсан гэж үү? • 2

даатгагдсан сайн мэдээ нь туйлын үнэнг заадаг. Энэ нь зөвт байхыг хичээн зүтгэх тухай биш, харин Ертөнцийн Эзэний хувьд туйлын зөвд тооцогдох тухай билээ. Хүн төрөлхтөнд зөвт хүн алга учраас Бүтээгч Эзэн хуучин хүн төрөлхтөнийг Загалмай дээр эцэс болгосон бөгөөд цоо шинээр бүтээх болно. Энэ замаар Тэрээр зөвт үйлсгүй, сүсэг бишрэлгүй хүмүүсийг ч гэсэн зөвтгөх болно гэж Паул бичив. Гэвч өөрийн зөвт байдлаа тогтоохыг эрмэлзсээр буй хүмүүс Ертөнцийн Эзэний зөвт байдлыг мэдэхгүй. Тэд хоёр сайн мэдээний аль алиныг ч ойлгоогүй хэрэг.


Энэ нийтлэлд та бид хоёрын авралтай шууд холбоотой, бас зөрчилдөх бололтой хоёр ишлэлийг авч үзнэ. Сэдэв нь энэ: Бид аврагдахын тулд итгэлээ заавал сайн үйлс хийнгээ нотлох ёстой юу? Эсвэл дан итгэлээр зөвд


тооцогдсон учраас аврал маань хэдийн баталгаатай юу?

Уг нь өмнөх хэдэн нийтлэлд дэлгэсэн хоёр сайн мэдээний учрыг ойлгосон бол хариу нь ил тод. Гэтэл итгэгчид олон зууны турш яг энэ сэдвээр их маргалдаж ирсэн учраас энэ асуултыг энэхүү нийтлэлд тустай авч үзье.


Паул ба Иаков үйлсгүй итгэл дээр эвлэршгүй

Паулын зааснаар “эдүгээ” Ертөнцийн Эзэний туйлын зөвт байдал Мосегийн “хуулиас ангид” илчлэгдсэн юм (Ром 3:21-24). Энэ зөвт байдал хүний хийдэг үйлсээс огтхон ч шалтгаалахгүй гэсэн үг.





Хүн Ертөнцийн Эзэний цэвэр хайр ивээлээр “үнэгүй” зөвтгөгдөх болсон (Ром 3:24). “Үнэгүй” гэдэг нь “хүний хийсэн үйлсийг авч үзэлгүйгээр”, “зөв юм хийснийх нь төлөө биш”, “хуулийг биелүүлсний хариуд биш” гэсэн үг. Үүнд итгэсэн хүн одоо ч зөвтгөгдсөндөө баярлах болно. Энэ итгэлийг ч Ертөнцийн Эзэн “итгэлийн зөвт байдал”-ын хамт “үйлсгүй” хүнд бэлэглэдэг (Ром 4:4-5). Үүний жишээгээр Паул Абрахамыг дурддаг: “Абрахам, Бурханд итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон” (Ром 4:3,13).



Бүх үндэстэнд зориулсан энэ сайхан мэдээ нь израилчуудад зарласан сайн мэдээнээс үнэхээр өөр билээ. Тиймээс Иаков Израилын “арван хоёр овогт” (Иаков 1:1) захидал бичихдээ сайн үйлсгүй дан итгэлээр зөвтгөгдөн аврагдах тал дээр Паултай шууд зөрчилдсөнд гайхах юмгүй. Тухайлбал:

“...Хуулиар шүүгдэх ёстой хүмүүс шиг тийнхүү ярь, тийнхүү үйлд! ... Ах дүү нар минь, хэрэв хүн “Надад итгэл бий” гэсэн атлаа үйлсгүй бол ямар ашигтай юм бэ? Тийм итгэл түүнийг аварч чадна гэж үү? ... Итгэл нь хэрэв үйлсгүй бол өөрөө үхмэл юм. Гэвч хэн нэг чинь “Чамд итгэл байна, надад үйлс байна” гэж хэлж болох юм. Тэгвэл чи надад итгэлээ үйлсгүйгээр харуул. Би чамд итгэлээ үйлсээрээ харуулъя...” (Иаков 2:12-18).




Дан итгэлээр аврагдсан гэж үү? • 4

Иаков үгээ Мосегийн “Хуулиар шүүгдэх ёстой хүмүүс”-т бичсэнийг анхаарна уу! Товч хэлэхэд, Иаков: “Үйлсгүй итгэл ашиггүй, үхмэл, хэнийг ч аврахгүй” гэж тэдэнд хэлсэн. Харин Паул “үйлсгүй ч итгэлтэй хүн зөвтгөгдөнө” гэсэн. Паул, Иаков хоёрын энэ үгийг итгэгчид олон зууны турш хооронд нь эвлэрүүлэхийг хичээсэн. Эсвэл аль нэг талыг барьсан. Зарим нь “Иаковын захидал бол Библид ормооргүй сүрэлхэн чанартай” гэж хэлсэн Мартин Лютер шиг Иаковыг үздэггүй. Өөр олон итгэгч Иаковын үгийг илүүд үзээд түүний хэлснээр үйлсээрээ зөвт болохыг эрмэлзэх бөгөөд үүгээр Паулын үгийг үгүйсгэдэг.

ИТГЭЛ
+ ҮЙЛС
аврал ✓

Иаков

Дөрөвдөх ч боломжийн байр суурь бий. Тухайлбал: Иаков, Паул хоёрын үгийг өөр өөрийнх нь хүрээнд нь ойлгох ёстой. Аль аль нь өөрийн хүрээндээ үнэн зөв гэсэн үг. Иаков захидлаа Ертөнцийн Эзэний Хуулийн доор буй Израилд хандан бичсэн. Нийгэмд зориулсан ямар ч хууль хүний харьцангуй түвшин дээр байхаас өөр аргагүй. Харин Паул, тэр Хуулийг аваагүй, Ертөнцийн Эзэнтэй гэрээгүй үндэстнүүдэд хандан бичсэн. Бүтээгч Эзэний хүн төрөлхтөнд зориулсан туйлын зорилгын тухай Паул бичсэн. Энэ нь Мосегийн “хуулиас ангид”, харин дагахгүй байхын аргагүй байгалийн жам хууль шиг. Иймд бид Паул, Иаков хоёрын үгийг тус тустай хүрээнээс нь гаргаад хооронд нь эвлэрүүлэхийг оролдох хэрэггүй. Тэгэж



Дан итгэлээр аврагдсан гэж үү? • 5


оролдохоор үгийг нь зайлшгүй зөрчилдөхөд хүргэн, заахыг хүссэн үнэнийг нь ойлгомжгүй бантан болгон хольж хутгана. Тэрний оронд тэр хоёрын үгийг өөрийнх нь хүрээнд үлдээх ёстой.

Итгэлийг хүний өнцгөөс харсан нь

АВРАЛ: Дан итгэлээр үү, үйлсийн хариуд уу?	
<u>Эвлэрүүлэх:</u> дан итгэлээр ч үйлсгүй аврагдахгүй УТГАГҮЙ!!	<u>Иаковыг тоохгүй:</u> Дан итгэлээр ИАКОВЫГ ХАЯЖ БОЛОХГҮЙ!!
<u>Паулыг тоохгүй:</u> Заавал үйлстэй ПАУЛЫГ ХАЯЖ БОЛОХГҮЙ!!	Аль аль нь өөрийн хүрээндээ үнэн

Үйлсээр илэрхийлэгддэггүй итгэл эргэн тойрны хүмүүст лав харагдахгүй гэж Иаков хэлэхдээ итгэлийг хүний өнцгөөс үздэг. Тэгэхдээ үйлсгүй тийм итгэлийг “Бурхан бол ганц” гэдэгт итгэх итгэл гэж тодорхойлдог. Ийм итгэл “сайн хэрэг. Чөтгөрүүд ч мөн үүнд итгэдэг бөгөөд чичирдэг юм” гэсэн (Иаков 2:19). Ийм итгэл авралд хангалтгүй нь ойлгомжтой. Тийм ч учраас Бүтээгч Эзэний оршин байдагт итгэх юмуу “Есүсийг хүлээн зөвшөөрөх” нь аль ч сайн мэдээнд итгэх итгэл биш. Паул ч гэсэн тийм ерөнхий итгэлийн тухай бичээгүй. Жинхэнэ итгэл Их Эзэний танд зориулж бичсэн үгэнд итгэж найдахад оршино.

Иаковын хувьд итгэл Ертөнцийн Эзэний Израилд тусгайлан өгсөн Хуулийн үгийг мөрдөхтэй зуун хувь холбоотой. Хууль өөрөө итгэлийг биш, дуулгавартай байхыг шаардах бөгөөд хүнийг хэр итгэлтэй байсны тал дээр бус, харин хэр дуулгавартай байсан тал



Дан итгэлээр аврагдсан гэж үү? • 6

дээр шүүдэг. Хуулийн шаардлаганд хүрэхгүй л бол дотроо итгэлтэй байсан, байгаагүй нь шүүлтэд хамаагүй. Хуулийн хэмжээнд зөвхөн бодит үр дүн гаргадаг тийм итгэл хүнийг аварна гэж Иаков сануулсан. Иаков ердөө л хүний итгэлийг харж, харьцангуй түвшинг барьдаг.


Христийн туйлын итгэлийг харах нь

Харин Паул юуны өмнө туйлын итгэлийн тухай бичдэг. Ертөнцийн Эзэний өнцгөөс харахад Есүс Христийн итгэл хамгаас чухал. “Хуулийн дор төрсөн” Тэрээр (Галат 4:4) Ертөнцийн Эзэний Израилд өгсөн Хуулийг бүрэн дүүрэн мөрдөн дагасан. Тэгээд Ертөнцийн Эзэн Өөрийг нь загалмай дээр бидний гэмийн улмаас нирвэж алуулах үед ч гэсэн Есүс Аавдаа бүрэн итгэж найдсан хэвээрээ (Дуулал 22).

Чухам юунд итгэсэн гэвэл, Ертөнцийн Эзэний хийдэг бүхэн зөв бөгөөд бүгдийг сайн сайхан үр дүнд хүргэх болно. Мөн, Аав нь Түүнийг үхэгсдээс амилуулахыг амалснаа биелүүлэх чадвартай бөгөөд найдвартайгаар биелүүлэх болно гэдэгт итгэлтэй



байв (Дуулал 16:10-11; Матай 12:40...). Түүний энэ итгэл лав Иаковын хэлснээр хийснээс нь харагддаг. Есүс Христийн загалмай дээр харуулсан итгэл бол юунаас ч илүү эрхэм чухал. Зөвхөн



Дан итгэлээр аврагдсан гэж үү? • 7

Түүний итгэл туйлдаа хүрэхдээ ч ганхаагүй, туйлын тууштай, туйлын үнэнч байсан.

Паулаас өөр хэн ч Есүс Христийн итгэлийн тухай бичээгүй (итгэлийг нь Паул бас Ром 3:26; Галат 2:16; 3:22; Филиппой 3:9-д дурдсан).


Харин Есүс Христийн туйлын итгэл бидний авралыг баталсан учраас хамгаас чухал итгэл мөн.

Христийн итгэлийн ачаар Ертөнцийн Эзэн зөвт байдлаа хүмүүст хүртээдэг болсон учраас тэр. Үүнд: **“Есүс Христийн итгэлээр Ертөнцийн Эзэний зөвт байдал нь бүгдийн төлөө бөгөөд итгэгч бүхний дээр байна.”** (Ром 3:22, грек эхийн дагуу орчуулав). Библийн олон орчуулганд “Христийн итгэл” гэхийн оронд “Христэд итгэх итгэл” гэж орчуулсан ч бидний авралын үндэс бол Есүс Христийн ялангуяа загалмай дээр байхдаа Аавдаа тавьсан итгэл мөн.

Ертөнцийн Эзэн Өөрийн зөв шударгаа батласан нь

Христийн туйлын итгэл Ертөнцийн Эзэний зөвт байдлыг “хуулиас ангид” илчилсэн билээ (Ром 3:21). Мосегээр өгсөн Хууль нь Ертөнцийн Эзэний шударга зөвийг тодорхой хэмжээгээр харуулах учиртай. Гэвч Хууль нь Түүний зөвт байдлыг хүнд хүртээж чадахгүй. Харин ч гэм нүглийг шийтгэхдээ үхэл авчирдаг. Тэгэхдээ Хууль зөвхөн тодорхой гэмт хэргийг шийтгэдэг, харин муу муухай






бодол, хүнийг гомдоох үг, хувиа хичээсэн зан зэрэг олон буруу зүйлийг засахгүй. Гэм бурууг шийтгэхгүй өнгөрөөх нь шударга ёсны эсрэг бөгөөд Ертөнцийн Эзэн Өөрөө зуун хувь зөв шударга биш байсан бол хүнийг зөвтгөж чадахгүй байхсан гэж Паул анхааруулдаг. Иймд Ертөнцийн Эзэн орчлон ертөнцийн өнгөрсөн, одоогийн, мөн ирээдүйн бүх гэм нүглийг Христийн загалмай дээр

нэгмөсөн шийтгэжээ. Тэгэхдээ Өөрийгөө туйлын зөвт болохоо батлан харуулсан.

Үүнд: **“Урьд үйлдэгдсэн нүглүүдийг Бурхан тэвчиж өнгөрүүлсэн**

учраас... Өөрөө зөвт байж, Есүсийн итгэлээс гарсан нэгнийг зөвтгөгч байхын тулд Ертөнцийн Эзэн эдүгээ цагт Өөрийнхөө зөвт байдлыг ийнхүү батлан харуулсан” (Ром 3:25-26, грек эхнээс хийсэн орчуулга).



Христийн туйлын итгэлд залгагдах бидний итгэл

“Есүсийн итгэлээс гарсан нэгэн” бол Түүний хийсэнд итгэл найдвараа тавьж, өөрийгөө Түүн шиг Ертөнцийн Эзэнд даатгаж, Түүний итгэлийн үр жимс болох хүнийг хэлнэ. Түүний араас дагах итгэл маань биднийг Түүнийх болсныг баталдаг.




Ертөнцийн Эзэн зүрх сэтгэлийг маань хардаг учраас итгэлтэй эсэхийг нь үйлсээр минь харж дүгнэх шаардлагагүй нь мэдээж. Тэртэй тэргүй бидэнд буй итгэл хүртэл Ертөнцийн Эзэний хайр ивээлээр өгсөн бэлэг юм. Үүнд: **“нигүүлслээр та нар итгэлээрээ аврагдсан юм. Энэ нь та нараас биш харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр биш аж. Тиймээс хэн ч өөрөөрөө сайрхахгүй болно”** (Эфэс 2:8-9).

Бидний итгэл нь вагон хөдөлгүүртээ залгагдах мэт Христийн итгэлд залгагдсан. Хөдөлгүүргүй вагон хаашаа ч явахгүйн адил бидний итгэл Христийн итгэлгүйгээр юунд ч хүрэхгүй.

Харин
Түүнтэй
нэгдсэн
байхдаа
бид
Ертөнцийн
Эзэний
зөвт
байдлыг
хүртнэ.
Үүнд:
“...бид



аливаа хүн Хуулийн үйлсээр бус, харин [Христ Есүсийн итгэлээр л] зөвтгөгддөгийг мэднэ. Тиймээс бид Хуулийн үйлсээр бус, харин [Христийн итгэлээр] зөвтгөгдөхийн тулд Христ Есүст итгэсэн шүү дээ” (Галат 2:16, [ийм хаалтан доторх үгийг грек эхийн дагуу засав]).




Ариун Сүнс үйлсийн маань хариуд гайхамшиг хийдэггүй

Галатчуудад Паул дээрх үгийг бичээд тэднээс лавлан: **“Та нар Сүнсийг хэрхэн хүлээн авсан юм бэ? Хуулийн үйлсээр үү, эсвэл сонссондоо итгэснээр үү? ...Та нарыг Сүнсээр хангаж, та нарын дунд гайхамшигийг үйлддэг Тэрээр үүнийг Хуулийн үйлсээр үйлддэг үү, эсвэл сонссондоо итгэснээр чинь үйлддэг үү? Яг үүнчлэн Абрахам “Бурханд итгэсэн бөгөөд үүгээр нь түүнийг зөвд тооцсон” юм”** гэжээ (Галат 3:2,5-6).

Абрахам хүүтэй болж, олон үндэстний өвөг эцэг болоод хорвоогийн бүх үндэстэнг ивээх гэсэн амлалтуудыг биелүүлэх гэж өөрөө юу ч хийж чадаагүй билээ. Энэ сайхан мөрөөдлын гэмээр ирээдүйн тухай Ертөнцийн Эзэний өөрт нь хэлсэн “сайн мэдээг” Абрахам сонсоод зүгээр л итгэсэн. Тэгээд олон жилийн дараа Ертөнцийн Эзэн 100 настай Абрахам, 90 настай Сара хоёрыг ч амийн хүч болох “сүнсээр хангаж,” дунд нь “гайхамшигийг үйлдэж” хүүтэй болгосон билээ.



Абрахам шиг Ертөнцийн Эзэний өөрсөд нь хэлсэн сайн мэдээнд зүгээр л итгэсэн хүмүүс “Абрахамын хамт ерөөгдсөн”, өөрөөр хэлбэл Абрахам шиг зөвт тооцогдсон (Галат 3:7-9).



Абрахамын итгэл ба үйлс


Сонирхолтой нь, Иаков өөрийн байр сууриа батлах гэж Паулын адил Абрахамыг жишээ болгон татаад зогсохгүй, яг л Паулын иш татсан үгийг ч мөн иш татдаг. Үүнд:

“Бидний эцэг Абрахам тахилын ширээн дээр хүү Исаагаа өргөхдөө үйлсээрээ зөвтгөгдсөн биш үү? Итгэл нь түүний үйлстэй хамт ажиллаж байсныг, итгэл нь үйлсээр гүйцэд болсныг ч харж байна. “Абрахам Бурханд итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон юм” гэж өгүүлдэг Бичвэр биелэгдсэн бөгөөд Абрахам нь Бурханы анд нөхөр гэж дуудагдах болсон. Хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөгийг та нар харж байна.” (Иаков 2:20-24)

Абрахамыг Паул, Иаков хоёр тус бүртээ хэрхэн үлгэр жишээ болгосон нь их сургамжтай. Юуны өмнө Ертөнцийн Эзэний Үг үнэн нарийн бөгөөд оновчтой хараад бишрэхэд хүрнэ.

Паул хозлуулаагүй (хөвч хөндүүлээгүй) бидэнд хандан, Абрахамыг хозлуулаагүй байхдаа Ертөнцийн Эзэний үгэнд итгээд зөвтгөгдсөн тухай бичсэн. Харин Иаков хозлуулагдсан Израилд хандан, өвөг дээдэс Абрахамыгаа хозлуулсныхаа дараа Ертөнцийн Эзэнд итгэх итгэлээ үйлсээрээ харуулсан тухай бичсэнийг анхаарна уу!

Паул	Иаков
хозлуулаагүй үндэстнүүдэд	хозлуулсан Израилд
хозлуулаагүй Абрахамын	хозлуулсан Абрахамын
итгэлийн тухай бичсэн.	үйлсийн тухай бичсэн.



Абрахамын түүхийг эргэж харвал, Ертөнцийн Эзэн түүнийг “тэнгэрийн од шиг олон үр удамтай” болгоод, дэлхийн бүх овгийг түүгээр ивээх болно гэж анх амласан. Яг энэ явдлын тухай Паул ромчуудад, бас галатчуудад бичсэн.

Энэ амлалтыг биелүүлэх тал дээр Абрахам итгэлээ үйлсээр харуулах ямар ч боломжгүй. Тэр зүгээр л Их Эзэнд итгэсэн (Эхлэл 15:5-6).



Тэр “найдах аргагүй үед найдан итгэсэн” (Ром 4:18). Итгэл дүүрэн зүрх сэтгэлийг нь харсан Ертөнцийн Эзэн түүнийг зөвд тооцсон.

Үүгээр ч зогсохгүй, тэр амлалтаа батлах гэж Ертөнцийн Эзэн Абрахамын талаас юу ч шаардаагүй гэрээг түүнтэй хийжээ. Гэрээ хийгдэх үед Абрахам гүн нойронд автсан. Энэ нь тус гэрээг биелүүлэхэд түүний талаас хийх зүйл юу ч байхгүйг илэрхийлсэн (Эхлэл 15:7-21).

Үүнээс хойш түүнд амласан хүү 15-аад жил өнгөрсөн боловч төрөөгүй хэвээр байв. Тэгсэн ч гэсэн Абрахам Их Эзэнд итгэсэн хэвээрээ. Энэ л үед Их Эзэн олон жилийн өмнө хийсэн тэр гэрээний тэмдэг болгон хозлуулах зан үйлийг Абрахамын гэр бүлд оруулсан (Эхлэл 17).




Паул хозлолын тэмдгийг Абрахамын “хозлуулаагүй байх үедээ [итгэсэн] итгэлийнхээ зөвийн тамга” гэж нэрлэдэг (Ром 4:11). Хозлол орж ирсний дараах жил хүү Исаак нь төрсөн. Дахиад хэдэн жилийн дараа Их Эзэн тэр л хүүг “шатаах тахил болгон өргө” гэж Абрахамаас шаардаж, итгэлийг нь сорьжээ (Эхлэл 22).



Энэ л явдлын тухай Иаков бичсэн билээ. Энэ удаад Абрахам итгэлээ үйлсээр харуулах боломжтой байв. Хамгаас хайрт хүүгээ тахиx аян замд гарах нь Абрахамд эцэг хүний хувьд мэдээж дэндүү хэцүү. Дээр нь Ертөнцийн Эзэний шаардсан нь Абрахамын итгэлийг ихэд сэгсэрсэн байх. Энэ л хүүгээр дамжин Абрахамын олон үндэстний өвөг эцэг болох тухай Ертөнцийн Эзэний амлалт биелэгдэх ёстой буй за.






Тэгсэн ч гэсэн Абрахам Их Эзэний үгийг дагаж, итгэлээ жинхэнэ болохыг харуулсан. Мэдээж Ертөнцийн Эзэн сүүлчийн мөчид хүүгээ тахиx энэ өргөлийг зогсоосон. Тэгээд ганц хүүгээ Их Эзэнээс харамлаагүйн төлөө Тэрээр Абрахамд “тэнгэрийн од шиг олон” үр хүүхэд дээр “далайн эргийн элс мэт асар олон” үр хүүхдийг нэмж өгөхөөр амласан. Абрахам дуулгавартай байсны төлөө үр удмаар нь газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөх болно гэж Их Эзэн дахин амалсан.

Иаковын үзлээр Абрахамын энэ үйлс итгэлийг нь “гүйцэд болгож”, иш татсан Бичвэрийг “биелүүлсэн” (2:22-23). Иймд Абрахам үнэн хэрэгтээ үйлсээрээ зөвтгөгдсөн гэж Иаков дүгнэдэг (2:21).

Хозлогсдын авралд үйлс шаардлагатай

Иаковын ойлголт нь Израилд өгөгдсөн Хуулийн хүрээнд зөв. Израилынхан эрт дээр үед Их Эзэний Хуулийг дагахаар амлаж, Түүнтэй гэрээ хийсэн билээ. Энэ замаар тэд “бүх ард түмний дундаас” Ертөнцийн Эзэний “нандин өмч” болжээ (Египетээс гарсан нь 19:3-8). Ертөнцийн Эзэний Хуулиараа тэдэнд өгсөн үгийг дагавал (эсвэл дагаж чадаагүй тохиолдолд уучлалт гуйвал) тэд зөв хүнд тооцогдоно. Энэ бол Мосегийн хэлсний дагуу. Тухайлбал: “Бид Түүний тушаасан ёсоор ЭЗЭН Бурханыхаа өмнө энэ бүх тушаалыг дагахдаа хянуур байх аваас тэр нь бидний зөвт байдал болно” гэжээ (Дэд хууль 6:25, АБ).



Хуулийг “Бурханыхаа өмнө” дагаж зөвтгөгдөх тухай Мосе ярьсныг анхаарна уу! Яг энэ байдлаар өмнөх нийтлэлд авч үзсэн Захариа, Елизабет хоёр “Бурханы өмнө зөвт байлаа”. Жич: “Өмнө” гэсэн орон цагийн нэр Ертөнцийн хаа сайгүй оршигч Эзэнийг нэг ёсондоо орон зайнд байрлуулдаг учраас хүний хүрээнд хэлсэн үг болохыг мэдүүлнэ.


Иаковын үзлээр амин сүнс бие махбодийг амилуулдаг шиг үйлс итгэлийг амилуулдаг (“Сүнсгүй бие үхмэл байдгийн адил үйлсгүй итгэл ч бас үхмэл болой” 2:26). Өөрөөр

хэлбэл, израилынхны хувьд итгэлийг нь харуулсан үйлс бол амь. Израилынхан Есүсийг амласан Аврагч Хаан мөн гэдэгт итгэхээс гадна аврагдаж, Хаант улсынх нь иргэн болохын тулд тэрхүү



итгэлд тохирсон сайн үйлс хийх нь зайлшгүй хэрэгтэй гэсэн үг. Үйлс нь ирээдүйн эон үеүдийн “мөнхийн амьдрал” хүртэх зам болдог гэсэн үг. Тийм учраас Иаков тэдэнд: “өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид [грек: хийгчид] бологтун” гэж бичив (Иаков 1:22).

Хуулийн дор буй хүмүүсийн тухай Паул Мосе ба Иаковтой санал нэг: “Хуулийг биелүүлэгчид [грек: хийгчид] нь Бурханы өмнө зөвтгөгдөх болно” гэжээ (Ром 2:13).




	ПАУЛ (Ром 4)	ИАКОВ (Иаков 2)
Захидал хүлээн авагчид:	Бүх үндэстэн “хуулиас ангид”	Израилын 12 овог “Хуулиар шүүгдэх ёстой хүмүүс”
гэдний байдал:	хозлуулаагүй Ертөнцийн Эзэнтэй гэрээгүй	хозлогдсон Ертөнцийн Эзэнтэй гэрээтэй
Абрахамын	Эхлэл 15	Эхлэл 22
...нас	эхний амлалтыг авахдаа: 75 (Эхлэл 12:4)	хүүгээ өргөхдөө: 115 орчим
...хозлолын байдал	хозлуулаагүй	хозлогдсон (99 настайгаасаа, Эхлэл 17:24)
...итгэсэн гол зүйл	-“Үр удам чинь од шиг олон байх болно” (Эхлэл 15:5) -“Их Эзэн үхэгсдийг [үхмэл биеийг] амилуулагч, байхгүйг байгаагаар дуудагч” (Ром 4:17)	-“Бурхан бол үхэгсдээс [алуулсан хүнийг] хүртэл амилуулах чадалтай” (Еврей 11:19 – Иаков үүнийг дурдаагүй)
...хүүхдийн тоо	0	2
...хийсэн зүйл	юу ч хийгээгүй, унтаад өгсөн (Эхлэл 15:12)	аян замд гарч, хүүгээ тахиx шахсан
...итгэл	найдах аргагүй үед (Ром 4:18) Абрахам Их Эзэний хэлсэнд итгэж найдсан.	итгэл нь үйлсээр гүйцэд болсон, өмнөх Бичвэр биелсэн (Иаков 2:22-23)
...тухай дүгнэлт	итгэлээрээ зөвд тооцогдсон (Ром 4:9)	үйлсээрээ зөвтгөгдсөн (Иаков 2:21)
...үр удам	-тэнгэрийн од шиг олон болно (Эхлэл 15:5), “одон үр” -итгэлийн үр (Ром 4:16)	далайн эргийн элс мэт арвин болно (Эхлэл 22:17), “элсэн үр” -хуулийн үр удам (Ром 4:16)
Абрахам хэний эцэг вэ?	-Хозлуулалгүй итгэдэг бүх хүний эцэг (Ром 4:11) -хозлолоос нь өмнө байсан итгэлийнх нь мөрөөр мөшгөгч хозлуулсан хүмүүсийн эцэг (Ром 4:12)	Израилын 12 овгийн өвөг эцэг (Иаков 2:21)




Христийн Биеийнхэн дан итгэлээр аврагдсан

Гэтэл Паул захидлуудаа “Хуулийн дор байгаа бус” хүмүүст хандуулж (Ром 6:14), Христийн итгэл үйлс ба “хуулиас ангид” буй зөвтгөлийн тухай тэдэнд заасан билээ. Зөвтгөгдсөн хүн Христийн Биед ордог бөгөөд Ертөнцийн Эзэн тэр хүний сайн, муу ямар ч үйлсийг авч үзэхгүй, харин түүнийг шууд Христийн адил зөвт гэж үздэг. Христийн Биеийнхэн Тэргүүнтэйгээ сүнс нэг, хувь заяа нэг (1 Коринт 6:17). Зөвтгөл бол баталгаат аврал юм.



Израилынхан хүний гараар махбодод хийгддэг хозлолоор тамгалуулсан бол Христийн Биеийнхэн Ариун Сүнсээр тамгалуулсан (Эфэс 1:13). Бид авралаа алдах боломжгүйг энэ мөн нотолдог. Христийн Биеийнхэн бид “үйлсийн сүнс”-ээр явж, итгэлээ үзүүлэх шаардлагагүй (Иаков 2:26), харин “итгэлийн Сүнс” нь (2 Коринт 4:13) биднийг хөдөлгөж, Түүний хүсснээр зөв үйлс хийхэд хүргэдэг.

Бусад хүнд бидний “Есүсийн итгэлээс гарсан” буюу “Христийн дотор байх” эсэх нь мэдээж харагдахгүй. Зарим итгэгчийн амьдралаас сайн үйлс харагдахгүй байж болох ч Их “Эзэн Өөрийн хүмүүсийг таньдаг” (2 Тимот 2:19).



Хэрэв аврал маань үнэхээр “нигүүлслээр юм бол цаашид үйлсээр биш ажээ. Эс тэгвэл нигүүлсэл нь нигүүлсэл биш болно” (Ром 11:6).

Аврагдахад үйлс маань нөлөөгүйг Паул олон дахин, сүүлчийн захиандаа хүртэл бичсэн. Үүнд:

“Бурхан биднийг ажил үйлсээр минь биш, харин Өөрийнхөө зорилго болон бүх л өнө мөнхөөс Христ Есүс дотор бидэнд соёрхсон нигүүлслийн дагуу аварсан” (2 Тимот 1:9).


Өөрийнх нь хувь нэмэр ордоггүй энэ авралыг олон хүн даанч хүлээж авч чадахгүй, “дэндүү амархан”, “хэт хямд” гэж үздэг. Хүмүүс ихэнхдээ өөрсдөө чармайн байж, гавъяа байгуулах хүсэлтэй. Хүний зүтгэлээр бус, Христийн итгэлээр шууд зөвтөгдөхийг Паул “загалмайн бүдрүүлэх саад” гэдэг (Галат 5:11).

Абрахамд амлагдсан “одон үр” ба “элсэн үр”

Абрахам хоёр янзын үр удамтай болохыг «Эхлэл» номд зөгнөсөн байна. Ертөнцийн Эзэн анх нэгэн шөнө Абрахамыг гадаа гарч, тэнгэрт гялалзах оддыг “тоолж чадах аваас тоол” гэсэн. “Үр удам чинь ийм олон болно” гэлээ.

Үүнийг сонсоод Абрахам “ЭЗЭНд итгэсэнд Эзэн үүгээр нь түүнийг зөвт тооцов” (Эхлэл 15:6, АБ).






Эдгээр “одон үр” нь Абрахамын “итгэлийн үр удам” буюу тэнгэр өөд чиглэсэн дуудлагатай Христийн Биеийнхнийг хэлнэ. Их Эзэний үгэнд Абрахам шиг итгэдэг “итгэлийн хүмүүс нь Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав” (Галат 3:7). Абрахамыг Ертөнцийн Эзэн “хозлуулаагүй итгэдэг бүх хүний эцэг болгож, тэднийг зөвд тооцуулахын тулд ажээ... Абрахам нь үхэгсдийг амилуулагч, байхгүйг байгаагаар дуудагч, өөрийн итгэсэн Бурханы өмнө бид бүгдийн эцэг юм” (Ром 4:11,16-17).

Олон жилийн дараа Абрахам хозлуулсныхаа дараа итгэлээ шалгуулж, олон үр удмыг нь гаргах ёстой ганц хүүгээ Их Эзэнд өгсөний дараа Их Эзэн түүнд “тэнгэрийн од шиг олон” итгэлийн үр удмаас гадна мөн “далайн эргийн элс мэт асар олон” үр удмыг нэмж өгөхөөр амласан билээ. “Элсэн үр” бол жам ёсоор махбодоос төрөх, Абрахамын үр удмыг хэлнэ. Энэхүү “үр удмаар дамжин газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдөх болно” хэмээн Их Эзэн амлажээ (Эхлэл 22:18). Иаковын захидлаа бичсэн арван хоёр овог бол тэр элсэн үрд хамрагдана. Өвөг эцэг Абрахамынх нь дуулгавартай байдалтай нэгдсэн итгэл тэдний ерөөлийн үндэс болсон.





Тэд түүний адил итгэлээ үйлсээр батлан харуулвал аврагдах болно. Жич: тэдний хувьд “аврал” нь мянган жилийн Хаант улсад орохыг хэлнэ.

Есүс Христ удахгүй эргэн ирж, тэдний дундаас “Өөрийг нь

хайрлагсдад амласан хаанчлалыг”

байгуулах болно

(Иаков 2:5). Тэр үед

газар дэлхийн бүх

үндэстэнг ивээн

ерөөх тэдний цаг

ирнэ.

Өнөөдрийн байдлаар

хозлолынхон

үндэстнүүдэд ивээл болохгүй байна. Тэд үндэстний

хэмжээнд Есүс Христээс татгалзсан учраас

Ертөнцийн Эзэний ивээлийг бусдад дамжуулах

суваг нь нэг ёсондоо бөглөрчээ.



Иймд Ертөнцийн Эзэн зөвт байдлаа бүх

үндэстнүүдэд шууд л үнэгүй өгөхөөр шийджээ.

Паулын зарласан сайн мэдээнд итгэсэн хэн бүхэнд

Тэрээр газар дэлхийн Хаант улсад орохоос ч хол

илүү дээр тэнгэрлэг хувь заяаг бэлдсэн байна. Иймд

Абрахамын эцэст харуулсан үлгэр дууриалыг ба

авсан амлалтыг нь махбодоос нь гарсан үр удамд

нь үлдээцгээе. Ертөнцийн Эзэний энэ хайр ивээлд

хэн ч өөрийн үйлсээ нэмэхийг оролдох ёсгүй.

Биднийг ямар ч нөхцөлгүй аварсан тэр холцъгүй

цэвэр хайр ивээлийг бид та бүхэнд тунхагладаг. □



Элч Петр чухам яаж эрс өөр сайн мэдээ заадаг Паулыг Ертөнцийн Эзэний мэргэн ухааныг хүлээж авсанд тооцдог болсон тухай бид дараагийн нийтлэлд авч үзэх болно.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Barnes, A. (1870). *Albert Barnes' Notes on the Bible*. As found in the [MySword Bible study software program](#) (see note on 2 Cor 3:5)

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org